

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2021 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнав)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2021-06-28

Улаанбаатар хот

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт (зорилтын дугаар)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ (арга хэмжээний дугаар)	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2021 оны зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)	
					Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн, хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО						
3.2.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.						
3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэнэ.	5."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.	2020-2024	УУХҮЯ, "ЭҮ" ТӨҮГ, ТӨБЗГ	?	ТЭЗҮ-ийн тодотгол хийх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. 7.5% 123,446.0 сая төг.	ТӨБЗГ – ТӨУЗХ "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь өөрийн боловсруулсан зэсийн баяжмалыг тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор хайлуулан, боловсруулах металлурги-химийн үйлдвэр (МХҮ) байгуулах ТЭЗҮ-ийг БНХАУ-ын ENFI болон NFC консорциумтай хамтран боловсруулж, 2020 оны 9 дүгээр сард ТЭЗҮ-ийн эцсийн тайланг хүлээн авсан. УУХҮЯ-аас өгсөн чиглэлийн дагуу үйлдвэрийн Техникийн зөвлөл 2020 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр хуралдаж, ТЭЗҮ-ийг хүлээн авах, Элементийн хүхэр үйлдвэрлэх технологийн "үйлдвэрлэлийн туршилт"-ын ажлыг эхлүүлэхийг дэмжих тухай 14/1 тоот шийдвэр гаргасан. Энэ шийдвэрийн дагуу үйлдвэрийн холбогдох инженер, техникийн ажилтнууд тус үйлдвэрлэлийн туршилтын техникийн даалгавар, гэрээний нөхцөл зэрэг баримт бичгийг боловсруулж, туршилтыг гүйцэтгэх China ENFI Engineering компани (тус технологийн цорын ганц патент эзэмшигч)-тай 6/005-21 тоот гэрээг 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулан ажиллаж байна. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ тус гэрээний дагуу China ENFI Engineering компанид 2021 оны 5 дугаар сард урьдчилгаа

					<p>төлбөрийг шилжүүлсэн. Төлөвлөгөөний дагуу ажил хэвийн явагдаж байна.</p> <p>Үйлдвэрлэлийн туршилтын үр дүнгээр МХҮ-ийн ТЭЗҮ-д тодотгол хийж, УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс, баялагийн мэргэжлийн зөвлөлөөр бэлтгэж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/99 дүгээр тушаалаар ҮТП-ын ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан төрийн байгууллагууд хоорондын ажлын уялдаа холбоог хангах, паркийн дэд бүтцийн төлөвлөлт болон техник, эдийн засгийн үндэслэлд заагдсан үйлдвэрүүдийг барьж байгуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p> <p>Ажлын хэсэг 2021 оны 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т ажиллаж, ҮТП-ын талбайн нөхцөл байдал, дэд бүтцийн хөгжлийн өнөөгийн байдал, хүчин чадлыг өргөтгөх боломжийг тодорхойлох, паркийн ТЭЗҮ-д тусгагдсан нэгж үйлдвэрүүдийн эрчим хүч, усан хангамж, төмөр зам, авто зам зэрэг дэд бүтцийг барихад шаардлагатай арга хэмжээний талаар санал солилцож, паркийн дэд бүтэц, нэгжүүдийн бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөөний талаарх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээлэлтэй танилцсан болно.</p> <p>Өөрийн үнэлгээ: 90 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор бэлтгэл, боловсруулалт, зохион байгуулалтын ажлууд хийгдсэн. Үр дүн гарч эхэлж байгаа. Технологийн патент эзэмшигчтэй гэрээ байгуулсан. Зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой тайлагнах шаардлагатай.</p>
6."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна.	2020-2022	УУХҮЯ, "ЭҮ" ТӨҮГ, ТӨБЗГ	?	<p>Үйлдвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, тусгай зөвшөөрөл авах. 50%</p> <p>83,685.5 сая</p>	<p>ТӨБЗГ – ТӨУЗХ</p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд "SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг тусгасан.</p> <p>Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүд исэлдсэн болон ядуу агуулгатай хүдрийг SX/EW технологиор боловсруулан жилд 10,000 тн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ болон нарийвчилсан инженерийн зураг төслийн суурь судалгаа, үндэслэл, техникийн</p>

					төг.	<p>даалгавар зэрэг баримт бичгийг боловсруулж, төслийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах тендерийг 2021 оны 5 дугаар сард 2 удаа зарласан боловч тендер амжилтгүй болсон. Иймээс тендерийг 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдөр дахин зарлаад байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 50 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор бодлого, төлөвлөлтийн ажлыг хийсэн. Зорилт, арга хэмжээний хэрэгжилт, түүний шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг хангах зорилгоор бэлтгэл, боловсруулалтын шатны ажил хийгдсэн. Шаардлагатай ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах тендер шалгаруулалтыг зохион байгуулсан боловч, үр дүн гараагүй байна.</p>
3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.						
3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулал-таар өргөжүүлэн хэрэгжүүлнэ.	1.Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.	2020-2024	БХБЯ, ТӨБЗГ	-	Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	<p>ТӨБЗГ – ТӨУЗХ</p> <p>Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК болон "Нийслэлийн орон сууцны корпораци" ХК-ийг нийлүүлэх замаар өөрчлөн зохион байгуулж, төрийн өмч давамгайлсан (жаран зургаан хувиас доошгүй) "Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци" ХХК байгуулах тухай асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын хуралдааны 13 дугаар тэмдэглэл гарсан. Уг тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Барилга, хот байгуулалтын сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагууд 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдөр нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Сандагсүрэн болон бусад холбогдох албаны хүмүүстэй уулзалт зохион байгуулав. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А-1/534 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабазарт уг асуудлаар хамтран ажиллах тухай хүсэлт хүргүүлсэн.</p> <p>"Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци" ХХК байгуулах асуудлыг 2021 оны 04 сарын 29-ний өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд "Нийслэлийн орон сууцны корпораци" ХК-ийг татан буулгаж, шинэ байгууллагад нэгтгэх асуудлаар ажлын хэсгийн дүгнэлт гаргахаар</p>

					<p>шийдвэрлэсэн.</p> <p>“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь шинээр байгуулагдах байгууллагын дүрэм, байгууллагын бүтэц бүрэлдэхүүний талаар Барилга, хот байгуулалтын яамтай хамтран тодорхой саналуудыг гаргаад байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдаж ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гаргасны дараа “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү асуудлыг хэлэлцэн зохих шийдвэр гаргана.</p> <p>Өөрийн үнэлгээ: 30 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор бэлтгэл, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжүүлж байна. Уг асуудлаар засаг захиргааны байгууллагын шат шатны түвшинд уялдаа холбоог хангах чиглэлээр ажилласан байна.</p>
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО					
4.1. “Цахим Монгол”- төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.					
4.1.4. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.	5.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно.	2021-2024	ТӨБЗГ	-	<p>ТӨБЗГ - ТӨБАХ, МТА</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн сангийн програм хангамжийг сайжруулан боловсруулах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, төрийн бусад мэдээллийн сантай холбох арга хэмжээг авч хэрэгжүүлэх асуудлаар санал, төсвийн урьдчилсан тооцоог бэлтгэж, Монгол Улсын 2021 оны төсвийн төсөлд тусгуулах арга хэмжээ авсан боловч улсын төсөвт шаардлагатай хөрөнгийн асуудал тусгагдаагүй.</p> <p>Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх асуудлын хувилбарыг судалж тодорхой арга хэмжээ авч ажиллаж байна. Үүнд:</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл мэдээллийн сангийн програм хангамжийг боловсруулах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, төрийн бусад сантай холбох арга хэмжээний ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулж байна.</p>

					<p>Төрийн өмчийн бүртгэлийн системийн програм хангамжийн асуудалтай холбоотой газар, үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл оруулах програмыг урьдчилсан байдлаар шийдвэрлэх, шинээр бий болгох програм хангамжийн бодлогын даалгавар боловсруулж, мэдээллийн систем бий болгоход шаардагдах нийт 1.2 тэрбум төгрөгийн зардлыг 2021 оны төсвийн тодотгол, 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт тусгуулах саналыг ЗГХЭГ-т болон Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.</p> <p>Төсөв, шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх арга замын хүрээнд мөн "Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн системийг шинэчлэн боловсронгуй болгоно" гэсэн арга хэмжээг Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгуулахаар холбогдох санал, үндэслэл, материалыг бэлтгэж, ТӨБЗГ-ын 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А-1/364 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Өөрийн үнэлгээ: 50 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, тухайн жилийн шалгуур үзүүлэлтийг хангах зорилгоор ТӨБЗГ нь өөрсдөөс хамаарах ажлыг гүйцэтгэсэн. Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар бодлогын баримт бичиг, төсөв, төлөвлөгөөнд тусгах талаар санал боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.</p>
<p>4.2.Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.</p>					
<p>4.2.4.Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх</p>	<p>1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт,</p>	<p>2021-2024</p>	<p>ТӨБЗГ</p>	<p>-</p>	<p>ЗУХ, ХЭЗХ, ТӨУЗХ, ТӨБАХ, ТӨХШХ</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн холбогдох баримт материалын хамт боловсруулж, ТӨБЗГ-ын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-1/362 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын статусын асуудлыг шийдвэрлэж, чадавх, үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүргийг тодорхой болгох асуудал тусгагдсан бөгөөд төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн өмчийг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэх тухай зааж өгсөн.</p>

асуудлыг таслан зогсооно.	нөхцөлөөр хангана.					<p>Түүнчлэн, Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь орон нутагт нэгжтэй байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан нь өнөөгийн Орон нутгийн өмчийн газрыг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангах боломжийг бүрдүүлнэ гэж үзсэн. Иймээс хуулийн шинэчлэлийн хүрээнд хийгдэх уг асуудал хууль хэрхэн батлагдахаас шалтгаална.</p> <p>Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын дагуу ТӨБЗГ-т хийгдсэн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр орон тоо нэмэгдэж, төрийн өмчид тавих хяналтын чадавх зохих түвшинд ахисан. Үүний үр дүнд, 2021 оны эхний хагас жилд төрийн өмчийн зохистой ашиглалт, хэрэглээг дэмжих үүднээс хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй газар дээр нь танилцаж, бараа, материалын үлдэгдэлд хяналт тавьж ажилласан. Тухайлбал, "Дулааны хоёрдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 7 жил ашиглалтгүй байсан Шингэн шилний үйлдвэрийг цаашид ашиглах, холбогдох зардлыг төлөвлөж шийдвэрлүүлэх асуудлыг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулан, ЗГХЭГ-ын төлөөлөлд тодруулга, тайлбар өгч, төрийн өмч үнэгүйдэж, ашиглалтгүй байгаа талаар зохих арга хэмжээ авах асуудлаар тогтоол гаргасан бөгөөд уг тогтоолоор Эрчим хүчний яаманд тодорхой үүрэг, чиглэл өгсөн.</p> <p>Мөн "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020, 2021 онд худалдан авсан хөрөнгө, бараа материалын талаарх судалгааг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 87 хуулийн этгээдээс авах ажлыг зохион байгуулж, мэдээллийг нэгтгэн холбогдох санал боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А-1/583 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Өөрийн үнэлгээ: 90 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор ТӨБЗГ нь өөрсдөөс хамаарах ажлыг гүйцэтгэсэн. Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг сайжруулах, төрийн өмчийг үнэгүйдүүлж байгаа асуудалд чиг үүргийн дагуу хяналт тавьж, тодорхой арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.</p>
	2.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой	2020-2024	ТӨБЗГ	-	25 хуулийн этгээдэд хяналт	<p>ТӨБЗГ – ТӨХШХ</p> <p>2021 оны эхний хагас жилийн байдлаар төрийн өмчит 6 хуулийн этгээдийн төрийн өмчийн эд хөрөнгийн захиран зарцуулалт,</p>

<p>хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна.</p>				<p>шалгалт хийсэн байна</p>	<p>ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд баримтын хяналт шалгалтыг хэрэгжүүллээ. ТӨБЗГ-ын хуралдаанд нийт 1.1 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн төрийн өмчит 3 хуулийн этгээд, 2019 онд хяналт шалгалтад хамрагдаж он дамжсан төрийн өмчит 1 хуулийн этгээдийн шалгалтын тайланг танилцуулж, хуралдаанаас гарсан саналыг “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” шийдвэрт тусган албажуулсан.</p> <p>Шалгалтын дүнгээр цаашид авч хэрэгжүүлэх 14 арга хэмжээ бүхий тогтоол, 18 зөвлөмж бүхий шалгалтын тайланг албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан.</p> <p>Төрийн өмчит 3 хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж байна.</p> <p>Өмнөх жилтэй харьцуулахад хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирсан дүнтэй байна.</p> <p>Орон нутаг дахь төрийн өмчит компани, үйлдвэрийн газарт хяналт шалгалт хэрэгжүүлэх зардлын төсөв батлагдаагүй, шинэ коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын улмаас улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт тодорхой хугацаанд ээлж дараатай шилжиж, хол хорионы дэглэм тогтоосон зэрэг нөхцөл байдалтай холбоотойгоор төлөвлөгөөт баримтын хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн.</p> <p>Өөрийн үнэлгээ: 50 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа, шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин 24 хувийн биелэлттэй. Хяналт шалгалтаар илэрсэн 1.1 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдлыг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн баталгаажуулсан. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжилтийг хангуулж байгаа. Цар тахлын нөхцөл байдал хяналт шалгалтын ажлын явцад нөлөөлж байгаа.</p>
<p>3.Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын</p>	<p>2020-2024</p>	<p>ТӨБЗГ</p>	<p>-</p>	<p>10 төсөвт байгууллагад шалгалт хийсэн байна.</p>	<p>ТӨБЗГ – ТӨХШХ</p> <p>ТӨБЗГ-аас 2021 онд гүйцэтгэх хяналт шалгалтын төлөвлөгөөнд төсөвт 10 байгууллагад хяналт шалгалт хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд эхний хагас жилд төрийн өмчийн төсөвт 5 байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын байдалд системийн хяналт</p>

	байдалд хяналт шалгалт хийж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ.					<p>шалгалт хэрэгжүүлэв.</p> <p>ТӨБЗГ-ын хуралдаанаар нийт дүнгээр 137.3 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн төрийн өмчит төсөвт 4 хуулийн этгээдийн шалгалтын тайланг хэлэлцүүлсэн. Шалгалтын дүнгээр цаашид авч хэрэгжүүлэх 23 арга хэмжээ бүхий тогтоол гарсныг 22 зөвлөмж бүхий шалгалтын тайлангийн хамт тухайн байгууллага бүрд албан бичгээр хүргүүлсэн, 1 байгууллагад хийсэн хяналт шалгалтын тайланг боловсруулж байна.</p> <p>Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дийлэнх хэсгийг төсвийн хөрөнгөөр бий болж байгаа эд хөрөнгөд хууль тогтоомжийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл аваагүй, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллаагүй байдал эзэлж байна.</p> <p>Системийн хяналт шалгалтад хамрагдсан 5 хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа хариуцсан 16 албан хаагчид Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан холбогдох тогтоол шийдвэрийг танилцуулж, төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, санал зөвлөмж өгч, харилцан санал солилцох уулзалт зохион байгуулан ажилласан байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 70 %</p> <p>Тэмдэглэл: Шалгуур үзүүлэлтэд заасан хүрэх түвшингийн 50 хувьд хяналт шалгалтыг хийж, шалгалтын дүн, дүгнэлтийн мөрөөр авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжилтийг хангаж байгаа. 137.3 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн баталгаажуулаад байгаа.</p>
4.4. Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.						
4.4.10. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит	1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай болон нутгийн тухай, өмчийн төрийн өмчийн оролцоотой этгээдийн хуулийг	2020-2023	ХЗДХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	?	Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. 20.0 сая төг.	<p>ТӨБЗГ – ХЭЗХ</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн холбогдох баримт материалын хамт боловсруулж, ТӨБЗГ-ын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-1/362 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Хуулийн төсөлтэй ЗГХЭГ-ын дарга танилцаж байгаа бөгөөд</p>

<p>болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.</p>	<p>боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p>				<p>яамдаас хуулийн төсөлд санал авахаар ажиллаж байна.</p> <p>Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, УИХ-д өргөн барих ажлыг ЗГХЭГ хариуцан ажиллаж байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 70 %</p> <p>Тэмдэглэл: Хуулийн төслийг дээд шатны байгууллага буюу хууль санаачлагчид хүргүүлсэн. Тавьсан зорилтод хүрэх зорилгоор ТӨБЗГ нь өөрсдөөс хамаарах ажлыг гүйцэтгэсэн.</p>
	<p>2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулж, батална.</p>	<p>2021-2023</p>	<p>ТӨБЗГ</p>	<p>-</p>	<p>ТӨБЗГ – ХЭЗХ</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн холбогдох баримт материалын хамт боловсруулж, ТӨБЗГ-ын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-1/362 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдаж, хуулийн шинэчлэл хийгдсэн тохиолдолд хэрэгжинэ.</p> <p>Хуулийн шинэчлэлийн хүрээнд дагалдах 13 дүрэм, журам батлагдах бөгөөд үүний 9-ийг Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас, 4-ийг Засгийн газраас тус тус батлахаар хуулийн төсөлд тусгагдсан байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 30 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдсэн, хуулийн төслийг боловсруулж, хууль санаачлагчид хүргүүлсэн. Хууль хэрхэн батлагдахаас үр дүн хамаарна.</p>
	<p>3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлнэ.</p>	<p>2021-2024</p>	<p>ТӨБЗГ</p>	<p>-</p>	<p>ТӨБЗГ – ТӨУЗХ</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалыг сайжруулах, олон улсын сайн туршлага, зарчмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Санхүү, эдийн засгийн их сургууль, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-тай хамтран ажиллаж, “Монгол шуудан” ХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Амгалан дулааны станц” ТӨХК, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Дулааны гуравдугаар</p>

					<p>цахилгаан станц” ТӨХК, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК зэрэг компаниудад засаглалын үнэлгээг хийлгэж дуусав.</p> <p>Компанийн засаглалын асуудалтай холбоотой “...төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал гэх тогтсон тодорхой загвар байж болох хэдий ч түүнийг бүтээх гол үндэслэл нь төр түүний хувьцааг эзэмшиж байгаа явдал гэдгийг ойлгож, тэрхүү хувьцааг олж авах, захиран зарцуулах, хувьцаанд ногдох эрхийг хэрэгжүүлэх механизмыг зөв тогтоох, энэ агуулгаар төр хувьцааг тооцоо, судалгааны үндсэн дээр тодорхой салбарт эзэмших, хувьцаа эзэмшигчийн ямар эрхээ аль байгууллагаар дамжуулж хэрэгжүүлэх хуваарилалт, хариуцлагын эргэх холбоо, тайлагнал, ил тод байдлыг хангах механизм”-ын талаар судлан холбогдох саналыг боловсруулж, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 70 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох сургалт, судалгааны байгууллага, ТББ-тай хамтран ажиллаж, компанийн засаглалын үнэлгээнд төрийн өмчит 9 компанийг шинээр хамруулсан байна.</p>	
	<p>4.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	2022-2024	ТӨБЗГ	-	-	<p>ТӨБЗГ – ТӨУЗХ</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 46 хуулийн этгээдийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан. Тэдгээр төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд нийт дүнгээр, 2021 онд 7.7 их наяд төгрөгийн орлого олж, 6.7 их наяд төгрөгийн зардал гарган 927.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн ба мөн онд татвар хураамж хэлбэрээр 1.6 их наяд төгрөг, 2020 оны цэвэр ашгаас төрийн өмчийн ногдол ашиг хэлбэрээр 184.6 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Засгийн газраас өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газруудыг хэмнэлтийн горимд шилжүүлж, шат дамжлага, чиг үүргийн давхардлыг арилгах замаар үйл ажиллагааны удирдлага, чиглэл, бүтэц, орон тоог оновчтой болгох, зардлыг бууруулах, хөрөнгийг үр</p>

					<p>ашигтай зарцуулж, зардлыг хэмнэхэд чиглэсэн ажлын хүрээнд төрийн өмчит хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захирал нарт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А-1/354 дүгээр албан бичгээр албан даалгавар хүргүүлж, сар бүр хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: 70 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээ 2022 оноос хэрэгжиж эхэлнэ. ТӨБЗГ-аас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын 2021 оны хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн үр өгөөжийг дээшлүүлэх, цар тахлын нөхцөлд үргүй зардлыг багасгаж, зардал хэмнэх, хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх асуудалд анхааран хяналт тавин ажиллаж байгаа.</p>
	<p>5.Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина.</p>	2021-2024	ТӨБЗГ	-	<p>Улсын тооллого зохион байгуулсан байна.</p> <p>ТӨБЗГ – ТӨБАХ</p> <p>1.Төрийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулахад шаардагдах төсөв (зардал)-ийг 2021 оны улсын төсвийн тодотголд тусган санхүүжүүлэх тухай саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>2.Коронавируст халдвар (ковид-19)-ын улмаас улсын үзлэг, тооллого явуулах ажил хойшлогдсон.</p> <p>3.Улсын үзлэг, тооллогыг 2021 онд явуулахад шаардлагатай хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй, цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хойшлогдсон тул уг арга хэмжээг Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгуулахаар холбогдох санал, үндэслэл, материалыг бэлтгэж, ТӨБЗГ-ын 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А-1/364 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Өөрийн үнэлгээ: 50 %</p> <p>Тэмдэглэл: Тухайн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, тухайн жилийн шалгуур үзүүлэлтийг хангах зорилгоор ТӨБЗГ нь өөрсдөөс хамаарах ажлыг гүйцэтгэсэн. Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар бодлогын баримт бичиг, төсөв, төлөвлөгөөнд тусгах асуудлаар санал тооцоолол боловсруулан дээд шатны байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх асуудлаар тодорхой арга хэмжээ авсан байна.</p>

ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ)-нд тусгагдсан арга хэмжээ (заалт) бүрийн хэрэгжилт, хүрэх түвшингийн үр дүнгээр тайлагнав. Нийт 2 бүлэг бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтод хамаарах 5 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээг ТӨБЗГ-т хяналтад авч, хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргав.

ТӨБЗГ нь хариуцан хэрэгжүүлэх 12 арга хэмжээний 11 арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар, 1 арга хэмжээ (4.4.10.1.)-ний хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар үүрэг хүлээсэн болно.

Үнэлгээний дүнг тооцохдоо Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2 болон 6.2.3-т заасан аргачлалыг хэрэглэсэн болно.

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:

ЗГҮАХХАХТ-нд тусгагдсан арга хэмжээ (заалт)-ний тоо – 12; Үүнээс:

- 90 %-ийн хэрэгжилттэй - 2 арга хэмжээ;
- 70 %-ийн хэрэгжилттэй - 4 арга хэмжээ;
- 50 %-ийн хэрэгжилттэй - 4 арга хэмжээ;
- 30 %-ийн хэрэгжилттэй - 2 арга хэмжээ;
- 0 % - 0.

ЗГҮАХХАХТ-ний тухайн жилийн зорилтот түвшингийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ – 60.0 % буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” байна.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

ТАЙЛАНГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЦЭРЭНЛХАМ